

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2016 оны 12 сарын 28 -ны өдөр

Говь-Алтай аймаг Цээл сум

НЭГ. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Говь-Алтай аймаг /нийслэл/-ийн Цээл сум /дүүрэг/-ийн Засаг даргын 2016 оны 11 -р сарын 07 -ны өдрийн А/69 тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж Цээл сум /дүүрэг/-ын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Баасанжав овогтой Насанбуян, газар ашиглагчийг төлөөлж /___ Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ___//иргэн, аж ахуйн нэгжийн нэр/ ажилтай “Алтайн Хүдэр” ХХК –ны Таян нуурын уурхайн Хууль зүйн хэлтсийн дарга Дашравдан Баттүвшин нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүй тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар ашиглуулагчаас газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн акт
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт.

ХОЁР. Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ 9.4 га /га/. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
1. ___ Баяжуулах үйлдвэрийн хойд талд ___	___ /га/
2. ___ Авто зогсоол, пүү ___	___ 9.4 га ___ /га/
3. ___ зориулалтаар ___	___ /га/
4. ___	___ /га/
5. ___	___ /га/

2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Нэгжийн үнэ 8000 төгрөг /үсгээр_ Найман мянган төгрөг ___ /төгрөг/

Бүгд үнэ 75200 төгрөг /үсгээр_ Далан таван мянга хоёр зуу ___ /төгрөг/

Үүнээс

1-р улиралд 18800 төг 3-р улиралд 18800 төг

2-р улиралд 18800 төг 4-р улиралд 18800 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн

ХААН банк 100050000943 тоот дансанд шилжүүлж байна.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

2.4 Газар ашиглах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тооцно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг ашиглагч хүлээнэ.

ГУРАВ. Газар ашиглагчийн эрх, үүрэг

- 3.1. Гэрээний нөхцлийн дагуу газрыг эзэмших, ашиглах
- 3.2 Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах
- 3.3 Газарт учруулсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх
- 3.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар гэрчилгээний хугацааг сунгуулах
- 3.5 Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх
- 3.6 Төлбөрийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийг үнийн дүнгийн 0,5 хувиар хоног тутам алданги төлөх
- 3.7 Ашиглалтын газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх
- 3.8 Газар ашиглуулагчаас газрын эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх
- 3.9 Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

ДӨРӨВ. Газар ашиглуулагчийн эрх үүрэг

- 4.1. Газар ашиглагч газрыг гэрээний дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах:
- 4.2 Уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.
Үүнд:
 - ✦ Газрын төлөв байдал чанарыг доройтуулахгүй байх, барилгаас 500м-т тохижилт, цэвэрлэгээг хариуцах.
 - ✦ Уурхайн өнгө үзэмжид тохирсон төмөр хашаа, хайс ашиглалтын талбайдаа татах.
 - ✦ Сумын тохижилт, зохион байгуулалттай холбоотой Орон нутгийн захиргааны шийдвэр, тогтоосон журмыг бүрэн биелүүлэх.
 - ✦ Газрын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь тогтмол бүрэн төлөх.
 - ✦ Тухайн газраа 2 жил дараалан гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй, Дээрх нөхцөлүүдийн аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд газар ашиглах эрх хүчингүй болно. /Захирамж гарсан өдрөөс эхлэн 2 жилийн хугацааг тооцно./
- 4.3 Газрыг гэрээний нөхцлийн дагуу ашиглаагүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу “Газрын тухай” хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах
- 4.4 Газар ашиглах гэрээг жил бүр дүгнэх
- 4.5 Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх

ТАВ. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

- 5.1 Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл Энэ тухай Газрын албанд 30-аас доошгүй _____ хоногийн дотор мэдэгдэх _____ гэж шийдвэрлэнэ.
- 5.2. Газар ашиглах эрх болон гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол тэр дагуу,

харин заагаагүй бол Уг газар дээрх барилга байгууламж бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү эд хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно гэж шийдвэрлэнэ.

5.3. Энэхүү гэрээгээр ашиглалтын газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь Монгол Улсын Газрын тухай хуулийн 35.3.5 дахь заалтыг мөрдөж ажиллана тус тус болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.4. Газар ашиглагчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

5.5. Гэрээний талууд шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Ашиглалтын газраа гэрээнд заасны дагуу зориулалтаар нь эзэмшиж ашиглана. Мөн гэрээг талууд жил бүр дүгнэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1 Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн Таван /үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

6.3 Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч: Говь-Алтай аймаг, Цээл сумын ЗДТГ-ын
Газрын харилцаа хариуцсан мэргэжилтэн Б.Насанбуян
Утас: 99062636

Газар ашиглагч: “Алтайн Хүдэр” ХХК
Таян нуур уурхай


Регистр /улсын бүртгэл/-ийн дугаар 5095549

Харилцах дансны дугаар _____
Харилцах утас _____


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:

Говь-Алтай Аймаг/нийслэл/-ийн
Цээл сум -ийн Газрын
асуудал эрхэлсэн албан тушаалтан
Баасанжав овогтой Насанбуян


/гарын үсэг/ /тамга/
Энэхүү гэрээний нэг хувийг 8212000386 тоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

Газар ашиглагчийг төлөөлж:


/гарын үсэг/ /тамга/